

Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтэд 2016 оны хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан.

2016 оны 07 дугаар сарын 05

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар 54 зорилтын 127 арга хэмжээг хяналтанд авснаас 18 арга хэмжээг дангаар, 30 арга хэмжээг толгойлон, 79 арга хэмжээг хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба эдгээрийн биелэлтэд 2016 оны хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Уул уурхайн яамны 2016 оны хагас жилд хэрэгжүүлсэн нийт 127 арга хэмжээнээс дангаар хэрэгжүүлсэн 18 арга хэмжээний биелэлт 91,7%, толгойлон хэрэгжүүлсэн 30 арга хэмжээний биелэлт 94,0%, хамтран хэрэгжүүлсэн 79 арга хэмжээний биелэлт 88,7%, нийт арга хэмжээний биелэлт 90,4%-ийн биелэлттэй дүгнэгдсэн.

Биелэлтэд үнэлгээ хийгээгүй:

Толгойлон хэрэгжүүлэгч байгууллагаас санал ирүүлээгүй, салбарын хяналтыг яаманд хамааруулах асуудал шийдэгдээгүй тул доорх 4 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй болно.

25.2. БНХАУ, Канад Улс болон Бүгд Найрамдах Сингапур Улстай байгуулсан давхар татварын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хэлэлцэн тохирогч улсуудтай хэлэлцээр хийж, саналаа холбогдох төслийг УИХ-д өргөн мэдүүлнэ.

106.2. Үйлдвэрүүдийг уялдаа холбоотойгоор, цогцоор нь байгуулах ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

235.1. Уул уурхай, газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд биологийн олон янз байдлыг боломжит өөр газарт дүйцүүлэн хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хэрэгжүүлнэ.

235.2. Байгалийн нөөц ашиглах болон үйлдвэрлэлээс үзүүлэх хуримтлагдах нөлөөлөл, байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг бүс нутаг, сав газрын хэмжээнд хийж, хохирлыг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Дүгнэлт.

Уул уурхайн яам нь Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор баталсан, Монгол улсын засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхайн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хангалттай сайн биелүүлж ажилласан байна.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:
ХШҮДАГ-ын дарга

Д.Жавхланболд

Тайлан бичсэн:
ХШҮДАГ-ын
Ахлах мэргэжилтэн

Б.Баяржаргал

2016 оны 07 сарын 5 өдөр